



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ**

2014 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 35

Шарга

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 дахь заалт, "Галт дулаан" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь заалтыг тус тус үндэслэн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаас **ТОГТООХ НЬ:**

1. Улсын төсвийн хөөрөнгөөр барих 320 хүүхдийн хичээлийн шинэ байрны зураг төсвийг хийлгэх ажлын хөлсөнд "Галт дулаан" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газраас 10 000 000 /Арван сая/ төгрөгийг гаргаж зарцуулахыг Засаг дарга /Д.Түмэнбаяр/, "Галт дулаан" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга /Д.Мягмар/ нарт зөвшөөрсүгэй.
2. Зураг төсвийг чанартай гүйцэтгүүлж тухайн зарцуулсан хөрөнгийг улсын төсвийн санхүүжилтээс буцаан төвлөрүүлж ажиллахыг сумын Засаг дарга /Д.Түмэнбаяр/, төрийн сангийн төлөөлөгч /Ш.Эрдэнэцэцэг/ нарт даалгасугай.
3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Л.Сэрсмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.АЗБАЯР